



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2022 он 04 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар ... ХТТ/805

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Ж.ЧИНБҮРЭН ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан “Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.” гэсэн зорилтын хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт: 6 хуудастай.


Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000225005672

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
2022 оны Х... тоот албан бичгийн хавсралт



## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ж.ЧИНБҮРЭНГЭЭС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

**Асуулга 1.Элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 50-иас дээш хувийг эмчилгээнд хамруулах ажлын явцын талаар:**

Эрүүл мэндийн сайдын дэргэдэх эрдэмтэд болон мэргэжлийн холбоодын судалгаагаар В вирусийн шалтгаантай элэгний архаг халдвартай нийт 260 мянган иргэн бүртгэлтэй, түүний 60% буюу 150.000 нь Б, Д вирусийн халдвартай байна.

HbsAg тээгч хүмүүсийн 60%-с дээш тохиолдолд элэгний Д вирус хавсарч илэрдэг. Элэгний Б, Ц вирустэй харьцуулахад Д вирусийн гепатит илүү хүнд, давшингуй явцтайгаар элэгний хатууралд шилжиж, элэгний дутагдалд эрт орж, улмаар үхэлд хүргэдэг.

Иймд иргэдийг элэгний Д вирусийн оношилгоо, шинжилгээнд эрт хамруулах нь элэгний вирусээс үүдэлтэй хорт хавдрын шалтгаант өвчний нас баралтыг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

1.1.Монгол улсад элэгний Д вирусийн оношилгоо, тандалт судалгаа, онош батлуулахад дараах оношлуурыг хэрэглэж байна:

- ХӨСҮТ-ийн Гепатит энтеровирусийн лабораторид Фермент холбоот эсрэг биеийн урвалын аргаар Итали улсын Delta biologicals компанийн DHV Ab оношлуур;
- Хятад улсын Beijing Wantai Biological pharmacy Enterprise компаний HDV-IgG оношлуур;
- Гепатит Д вирусийн мупер халдвар болон ко халдварын ялган оношилгоонд Итали улсын Delta biological компаний HDV-IgM оношлуур.

ХӨСҮТ-ийн гепатитын лаборатори нь гепатит Д вирусийн нуклейн хүчлийн хэмжээ тодорхойлох шинжилгээ хийж эхлээд байна.

1.2.Элэгний Д вирусийн эсрэг Bulevirtide (Hepcludex) эмийг Хүний эмийн зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/347 дугаар тушаалаар 2 жилийн хугацаагаар өнчин эмийн жагсаалтад оруулсан. Ингэснээр Монгол улс уг эмийг импортлон эмчилгээнд хэрэглэх нөхцөл бүрдсэн. “Омбол” ХХК-иас Bulevirtide эмийн эмчилгээний талаар Гилеад Сайенс компанийн эмч нар 2022 оны 04-р сард Монгол улсад ирж ажиллахаар төлөвлөж байгаа талаар мэдээлээд байна.

Түүнчлэн, “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/629 тоот тушаалаар байгуулагдан ажиллаж байгаа болно.

**Асуулга 2.Хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэж улсын хэмжээнд хэрхэн зохион байгуулах талаар:**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлэх, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, иргэн бүрийг эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Хүн амын дунд өвчлөл, нас баралтад хүргэж байгаа зонхилон тохиолдох өвчин эмгэгийг эрт илрүүлэн, оношилж цаашид даамжруулахгүй эмчлэх нь өвчний хүндрэл, нас баралтаас сэргийлэх, өвчний хожуу үе шатанд гарах эмчилгээний өндөр зардал, эмнэлгийн ачааллыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулах товлалыг Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/420 дугаар тушаалаар, шаардагдах зардлыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 19 дүгээр тогтоолоор тус тус баталж, холбогдох төсвийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, 18-аас дээш насны даатгуулагч насны бүлгээс шалтгаалан 43,000-75,000 төгрөгийн, 11 нэр төрлийн оношилгоо, шинжилгээнд хамрагдах боломжтой байгаа ч 2020 онд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд зорилтот насны иргэдийн 8.8 хувь нь буюу 153,155 хүн хамрагдан 6.5 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан бол 2021 онд зорилтот бүлгийн 4.4 хувь буюу 96,690 даатгуулагч хамрагдаж, даатгалын сангаас 4.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Цаашид хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог оновчтой, хүнд ээлтэй, нэгдсэн зохион байгуулалттай хэрэгжүүлэх нь нэн чухал тул уг зорилтын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/139 дугаар тушаалаар хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам батлагдсан.

Уг журмын дагуу 0-18 насны хүүхэд 4 нэр төрлийн, насанд хүрэгсэд 13 нэр төрлийн оношилгоо, шинжилгээнд хамрагдана. Ингэснээр хүн бүрт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авах тэгш боломж олгох, иргэдийн оролцоотой сонголтыг бий болгож, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээнд хувь хүний оролцоог нэмэгдүүлж, нотолгоонд суурилсан сонголтыг хамт хийх зохицуулалтыг оруулснаар шаардлагагүй оношилгоо, шинжилгээний тоог бууруулахад эерэг нөлөөтэй байх болно.

Түүнчлэн, 2022 оны 05 сарын 01-ээс мөрдөж эхлэх эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэхийн багцад элэг, уушиг, хөх, бамбай, умайн хүзүү, бүдүүн гэдэс, улаан хоолой, ходоодны хавдрын эрт илрүүлэг багтсан болно.

**Асуулга 3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд орчин үеийн үндэсний оношилгоо, эмчилгээний төвүүдийг бүтээн байгуулах ажлын явцын талаар тодорхой мэдээлэл:**

**1.Түлэнхийн төвийн талаар:** “Түлэнхийн төв” эмнэлгийг Монгол Улсын Засгийн газар, Арабын Эдийн засгийн Хөгжлийн Кувейтийн сангийн хооронд 2017 онд байгуулсан 8,0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн дагуу тус эмнэлгийг барьж байна. Үүний 6,8 сая ам.доллар нь А,В,С гэсэн үндсэн 3 блок барилга, тоног төхөөрөмж нь 1,2 сая ам.долларын санхүүжилттэй. Барилга угсралтын явцад дор дурдсан асуудал гарсан:

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/247 тоот захирамжаар моргийн барилга барих газрыг “Хамтын шийдэл” ТББ-д өгөх шийдвэрийг гаргасны улмаас эмнэлгийн моргийг В блок барилгын зоорийн давхар руу нүүлгэн шилжүүлсэн;

- Хөрсний ус гарч барилга байгууламжид нөлөөлсөн тул хөрсний усны түвшин доошлуулах системийг шийдвэрлэсэн.

Дээр дурдсан асуудалтай холбогдуулан 2020 оны төсвийн тодотголоор 3,0 тэрбум төгрөг Сангийн сайдын төсвийн багцад батлагдсан бөгөөд үүнээс А блокийн барилгын ажилд “Цаст констракшин” ХХК-тай 1,47 тэрбум, Б блокийн барилгын ажилд “Нутгийн зам” ХХК-тай 1 тэрбум төгрөгийн нэмэлт гэрээг тус тус байгуулж, санхүүжилт олгосон.

Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсгийг үндэслэн тус барилгын “А” болон “Б” блокийг хэсэгчлэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна:

- “А” блокийн барилгын дотор заслын ажил 100 хувь дуусаж, гаднах цахилгааны дэд өртөө, гаражийн ажил 95 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын байнгын ашиглалтад оруулах Улсын комисс 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр хэсэгчлэн ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах санал оруулсан ба 14 хоногийн хугацаанд комиссоос өгсөн үүрэг даалгаврын хүрээнд ажил хийгдэж, 2022 оны 5 сараас эмнэлгийн тусламж үйлчилгээг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

- “Б” блокийн барилгын дотор засал болон гадна тохижилтын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй 2022 оны 06 дугаар сард багтаан байнгын ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

**2.“Халдварт өвчин судлалын үндэсний төвийн салбар-II”-ийн талаар:** Барилга, хот байгуулалтын сайдын багцаас 1.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, “Халдварт өвчин судлалын үндэсний төвийн салбар-II” эмнэлгийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажилд “Урбан девалопмент” ХХК шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна.

Төв аймгийн Засаг Даргын захирамжаар тус аймгийн Сэргэлэн сумын 4 дүгээр багийн Бөхөгийн хөндийд эрүүл мэндийн байгууллагын зориулалттай 20 га газарт уг эмнэлгийг барих эрхийг олгосон.

Зураг төсөл, ТЭЗҮ 85 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба 2022 оны 06 дугаар сарын 31-ний өдрийн дотор Барилгын хөгжлийн төвийн Магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулан хүлээлгэн өгнө.

Мөн тус төслийг гүйцэтгэхэд шаардлагатай барилга угсралтын ажлын санхүүжилт одоогоор батлагдаагүй бөгөөд улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.



**3.Сүрьеэгийн эмнэлгийн барилгын талаар:** Сүрьеэгийн эмнэлгийн барилга нь нийт 5 блок бүхий 120 ортой цогцолбор барилга, байгууламж бөгөөд Баянзүрх дүүрэг, Чулуутын амны 1,5 га газарт төлөвлөгдсөн. 2019 онд зураг төсөл, ТЭЗҮ батлагдсан ба Барилгын хөгжлийн төвийн Магадлалын ерөнхий дүгнэлтээр 18,5 тэрбум төгрөгөөр батлагдсан.

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуульд Эрүүл мэндийн сайдын багцад “Сүрьеэгийн эмнэлгийн барилга /Улаанбаатар/” төслийн төсөвт өртөг нь 10 тэрбум төгрөгөөр батлагдан худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан.

Худалдан авах ажиллагааны үр дүнд гомдол гарсан ба Нийслэлийн анхан шатны шүүхээс гомдлыг шалгаж 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдөр тендерийн материалыг дахин үнэлэх шийдвэр гарсан бөгөөд дахин үнэлгээ хийгдэж байна. Мөн тус төслийн Магадлалын ерөнхий дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд Эрүүл мэндийн сайдын багцад төсөвт өртөг нэмэгдэн 18,5 тэрбум төгрөгийн төсөвтэйгээр батлагдсан.

**4.Геронтологийн үндэсний төвийн талаар:** Монгол Улсын 2011 оны Төсвийн тухай хуульд уг төслийн нийт төсөвт өртөг 4,724.0 сая төгрөг, санхүүжих дүн 500 сая төгрөгөөр батлагдсан.

Эрүүл мэндийн яам эхний тендер шалгаруулалтыг зохион байгуулахад нийт 6 аж ахуй нэгж тендер ирүүлснээс хамгийн бага нь 8,5 тэрбум төгрөгөөр үнийн санал ирүүлсэн учраас төсөвт өртөг хүрэлцэхгүйн улмаас тендер хүчингүй болсон.

Дахин тендер шалгаруулалтыг нийт 4 блок барилга байснаас Б,В,Г гэсэн 3 блок барилга лифтгүй, гадна тохижилтгүй, дотор цахилгаангүйгээр зохион байгуулан нийт 3 аж ахуйн нэгж тендер ирүүлснээс, “Арвис интернейшнл” ХХК-тай 2,998.0 сая төгрөгөөр 2011 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 2012 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд барилгын ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан.

Барилга угсралтын явцад зураг, төсөв алдаатай байсныг 2012 оны 09 дүгээр сард Эрүүл мэндийн яам Ажлыг хэсэг гарган, зураг төсвийг дахин шинэчлэн магадлал хийлгэн барилгыг үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд Барилгын хөгжлийн төвийн 2012 оны дүгнэлтээр барилгын төсөвт өртөг 7,392.8 сая төгрөгөөр магадлал хийгдсэн.

Эрүүл мэндийн яам гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний маргаанаа Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлэхтэй холбогдуулан уг барилгын ажил 2012-2018 оны хооронд царцсан.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд төсөвт өртөг 7,392.8 сая төгрөг, санхүүжих дүн 1,6 тэрбум төгрөгөөр батлагдсан. Барилгын Б, В, Г блокийн каркас бүрэн хийгдсэн, гадна ханын өрлөг 60 хувьтай, гадна дулаан, цэвэр бохир усны шугамын ажил тус тус хийгдсэн.

Үлдсэн А блокийн барилга захиргааны зориулалттай байсан бөгөөд тус блокийн өрөөнүүдийг нөгөө 3 блок руу шилжүүлэн, зураг төслийг өөрчилж /гадна шугам сүлжээ, гадна тохижилт, лифттэй болгосон/, 2019 онд магадлалаар баталгаажуулахад 17,6 тэрбум төгрөгөөр хянагдсан байна. Одоогоор барилга

угсралтын нийт ажил 46 хувийн гүйцэтгэлтэй ба 6,214.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсөвт өртгийн нэмэгдлийг 2021, 2022 оны улсын төсөвт нэмэгдүүлэхээр санал хүргүүлсэн боловч батлагдаагүй.

Жич: Монгол-Япон Улсын дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой 2022 онд тохиож байгаатай холбоотой тус барилгын санхүүжилтийг буцалтгүй тусламжийн хүрээнд Япон Улсаас шийдвэрлүүлэх хүсэлтийг Сангийн ямаар дамжуулан хүргүүлсэн.

**5.Эд, эс эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төвийн талаар:** Дэлхийн жишигт нийцсэн технологи, инноваци, дэвшилтэт эмчилгээ үйлчилгээ, Эс эмчилгээний эрин болж байгаатай холбогдуулан эсийн эмчилгээ хийх ба Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчлөлийг эмчлэх иж бүрэн төв болох юм. Уг төв нь Улаанбаатар хот Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хашаанд барихаар төлөвлөсөн бөгөөд 60.2\*30м хэмжээтэй цоколийн 2 давхартай, 8 давхар барилгатай байна. Мөн шаардлагатай дэвшилтэт тоног төхөөрөмж, мэргэжилтнүүдээр бүрэн хангагдсан байна.

Тус, төслийн ТЭЗҮ боловсруулагдсан бөгөөд 120.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг шаардлагатай. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр 2022 оны Монгол Улсын төсөвт санал хүргүүлсэн боловч батлагдаагүй байна.

**6.Зүрх судасны үндэсний төвийн талаар:** Монгол Улсын хүн амын дунд зүрх судасны өвчлөлийг тууштай бууруулж, урьдчилан сэргийлэх, тасралтгүй хянах болон төгс оношлон эмчлэхэд шаардлагатай орчин үеийн дэвшилтэт технологи, арга аргачлалыг нэвтрүүлэх чиглэлээр үр өгөөжтэй олон арга хэмжээг авч байгаагийн зэрэгцээ ард иргэдэд эх орондоо олон улсын түвшинд хүрсэн чанартай, аюулгүй тусламж үйлчилгээг ая тухтай орчинд авах боломжийг бий болгох зорилгоор “Зүрх Судасны Үндэсний Төв”(ЗСҮТ) байгуулах төслийг Монгол Улсын Засгийн Газар, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр ТЭЗҮ, зураг төслийг боловсруулсан.

Тус эмнэлгийн барилга нь Улаанбаатар хот, Улсын гуравдугаар эмнэлгийн хашаанд төлөвлөгдсөн ба зураг төсөл, ТЭЗҮ -г Испани Улсын “Идом” ХХК 1,5 сая еврогоор гүйцэтгэж, барилга угсралтын ажлын дүн 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажсан.

Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр 2021, 2022 оны Монгол Улсын төсөвт санал хүргүүлсэн боловч батлагдаагүй байна.

**7.“Хавдар судлалын үндэсний төв-II”-ын талаар:** Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн Барилга, Хот байгуулалтын сайдын багцад 1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Хавдар судлалын үндэсний төвийн салбар эмнэлэг-II” цогцолборын зураг төсөл батлагдсан бөгөөд “Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК шалгаран Барилга, Хот байгуулалтын яамтай гэрээ байгуулан ажиллаж байна.

Тус цогцолбор барилгын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажил 30 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.

Мөн тус цогцолбор барилгын анхны төлөвлөсөн байршил болох Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 8 га газар нь Байгаль орчин,

аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны А230/127 дугаар тушаалаар баталсан “Усны сан бүхий газар, Усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам” - д хамаарсан.

Иймд дахин шинэ байршил дахь газрын асуудлыг холбогдох Төрийн захиргааны байгууллагатай хамтран судалж байгаа бөгөөд хэд хэдэн байршлыг төлөвлөөд байна. Түүнчлэн, тус төслийг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилтийг 2023-2024 оны Улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.

-----oO-----